



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### XXIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 11:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-д 90 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлын талаар

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

2. Олон Улсын “Аравт-2021” морин цэргийн уралдааны талаар

ЗХЖШ-ын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн,  
Дэслэгч генерал Д.Ганзориг,

3. Иргэдийн зорчих хөдөлгөөн, цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар

ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн албаны дарга,  
Цагдаагийн хурандаа О.Ганбат

4. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтыг бууруулах, эрсдэлээс хамгаалах зорилгоор аймгуудад хөдөлгөөний ямар хязгаарлалт тогтоосон, хэрхэн зорчих тухай болон орон нутаг дахь халдварын нөхцөл байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдон үүсч болох хүндрэл, эрсдэлийн талаар иргэд, олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэх, хязгаарлалт тогтоосноос бусад аймаг, орон нутаг руу Улсын онцгой комиссын даргын 46 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу нэвтрүүлэх;

1.2. Аймаг, сумын Онцгой комисс 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн Улсын онцгой комиссын чиглэлгүйгээр хязгаарлалт тогтоох, өмнө тогтоосон хязгаарлалтын хугацааг сунгахыг хориглох;

1.3. Хөдөө, орон нутаг руу зорчиж байгаа вакцины бүрэн тунд хамрагдаагүй 5-аас дээш насны хүүхдээс түргэвчилсэн шинжилгээг түүвэрлэн авч нэвтрүүлэх (нэг өрхөөс нэг хүүхэд гэсэн зохицуулалтаар түүвэрлэн авах);

1.4. Хязгаарлалтын дэглэм тогтоосон эсэхээс үл хамаарч аймаг, сумын Засаг дарга, Онцгой комисс өөрийн нутаг дэвсгэр дээрх аялал жуулчлалын бүсэд байрлах шаардлага хангасан амралт, жуулчны газруудтай хариуцлагын гэрээ байгуулж, вакцины бүрэн тунд хамрагдснаас хойш 14-өөс дээш хоносон, өвчлөөд эдгэрсэн иргэд, тэдгээрийн хүүхэд нэг өрхийн хүрээнд, нэг өрхөөс бусад 5 хүртэлх хүнтэй аялалын баг бусад багтай нэгдэхгүйгээр үйлчлүүлэх боломжийг олгож иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

1.5. Орон нутаг дахь эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачаалал нэмэгдсэн, халдварын тархалтын эрсдэл өндөр болсон зэрэг нөхцөл байдлыг харгалзан иргэд, олон нийтийг эмнэлгийн яаралтай тусламж, эмийн сан, хүнс, шатахуун, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ авахаас бусад тохиолдолд суурин газар, хот айлаар орохгүй, вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 14-өөс дээш хоносон, өвчлөөд эдгэрсэн иргэд, тэдгээрийн хүүхэд нэг өрхийн хүрээнд, нэг өрхөөс бусад 5 хүртэлх хүнтэй аялалын баг бусад багтай нэгдэхгүйгээр байгалд амрах боломжоор хангах, ингэхдээ гол усны үер, ой хээрийн түймэр зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж аялж, амрах зөвлөмж, мэдээллийг бүх шатанд өгөх;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

2.1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор жирэмсэн эмэгтэй ажилтан, албан хаагчдын ээлжийн

амралтыг 7, 8 дугаар сард биеэр эдлүүлэх, ээлжийн амралтын эрх үүсээгүй эхчүүдэд цалинтай чөлөө олгох, ээлжийн амралтын хугацаа нь дуусгавар болмогц цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өвдсөн ажилтан, албан хаагчдад мөн адил цалинтай чөлөө олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

*Гурав. ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газарт:*

3.1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор жирэмсэн эмэгтэй ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтыг 7, 8 дугаар сард биеэр эдлүүлэх, ээлжийн амралтын эрх үүсээгүй эхчүүдэд цалинтай чөлөө олгох, ээлжийн амралтын хугацаа нь дуусгавар болмогц цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өвдсөн ажилтан, албан хаагчдад мөн адил цалинтай чөлөө олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай уриалга гаргаж хувийн хэвшлийн байгууллагад хүргүүлэх;

*Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт:*

4.1. Өмнөговь болон Дорноговь аймаг руу зорчих иргэдийн хөдөлгөөнд тогтоосон хязгаарлалтыг тодорхойгүй хугацаагаар сунгаж, төрийн байгууллагын албан томилолтоор зорчих иргэдийн зөвшөөрлийг Улсын онцгой комиссын Шуурхай штаб, бусад шаардлагаар зорчих иргэдийн зөвшөөрлийг ямар ч тохиолдолд коронавируст халдварын шинжилгээнийн сөрөг хариунд үндэслэн тухайн аймгийн Онцгой комиссоос олгох;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ОРЛОГЧ ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ